



Н.МАНДАЛ

Мудал ХҮХЭД



Надмидын Мандал

Мурдал
ХҮҮХЭД



Улаабаатар хот
2007 он

Н.МАНДАЛ

Мундаг хүүхэд

“Сайн хүүхэд болох нууц” цуврал

Бага сургуулийн сурагчдад зориулаав.

Зураач	Н.Батбадрах
Хянан тохиолдуулагч	О.Менхтуяа
Хянасан	Ж.Гэрэлмаа
Дизайнер	Т.Дэлгэрмаа




Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК

2007 он

Номоо уншаад зургаа зураарай.
Ганц гөлөгтэй хуудаснууд чинийх шүү.




Сацрал охин хичээлээ тараад гэртээ ирж явав. Орцондоо
ормогц тэр шатаар дуу аяланхан өгслөө. Тэднийх таван
давхар байшингийн гуравдугаар давхарт байдаг юм.



Тэгтэл орцных нь хоёрдугаар давхарт эзэнгүй гэлэг байж байх нь тэр ээ. Хархан үстэй тэр жаахан амьтан охиныг хармагцаа аврал эрэх мэт зөвлхөн гийнав.



Гелег даарсан байлаа. Хамаг бие нь дагжтал чичрэх аж. Түүнийг тэвэрсэн охин ч дагаад чичирч эхлэх шиг. Басхүү ихэд өлсэж буй нь илт. Хариугүй нимгэхэн хэлээ булталзуулаад л байв.



Дөрвөн нүдтийг гэртээ авч орохгүй гээд яах билээ? Ашгүй эзж нь хаалгаа хурдан тайлав. Охин бяцхан андаа малгайгаараа хүчсан тул эзж анзаарсангүй. Туунийгээ шалан дээр буулгахад л сая олж харлаа. Тэгээд “Энэ чинь юун гелег вэ?” хэмээн уулгалав. Золтой л “Гадагш гаргаж хая” гээд хэлчихсэнгүй.




Элдэв хог наалдсан үснээс нь хэн ч сэжиглэхээр байсан тул охин гөлгөө угаалгын өрөө рүү авч орлоо. Усийг нь савандаад бүлээн усаар угаав. Даарч байсан түүнд бүлээн ус таатай байсан нь мэдээж шүү дээ. Нэг ч дуу гаргалгүйгээр угаалгасан аж. Тэгээд ч ямар нэгэн шинэ орчинд дасахад тэвчээр л хэрэгтэй биз дээ!



Цэвэрхэн болсон гөлгийг ээж хараад өхөөрдөв. Чингээд жижиг тавганд хоол хийж өглөө. Идэхгүй болохоор нь бүлээн сүүгээр дайлав. Гелөг сүүнд л дуртай ажээ. Тавган дахийг долоосоор байгаад барчихлаа.




Сацрал охин бүхэл оройжин шинэ найзтайгаа тоглов. Гөлөг нэг бол охиныг элдэнэ. Нөгөө бол өөрөө зугтана. Хөөхдөө ч зугтахдаа ч ямар адтай хурдан гээ! Гэрийнхнээрээ хэлэлцэн байж түүнд Банхар хэмээх нэр өгчээ.




Охины аав шөнөдөө Банхарыг цаасан хайрцагт хийв. Цаасан хайрцагт зөвлөн ор зассаныг бичихээ мартаж болохгүй. Гэвч гөлөг тавтай унтсангүй. Тэр хашлагатай орноосоо гарахыг оролдон гасалсаар байлаа.








Шене нойр муутай хоносон хүмүүс гелгийг даруй явуулахын түүс болцгоов. Эж аав хоёр нь Сацралыг ятгасаар. Эзжийгээ санасан байх гэдэг дээр л үгссээр байжээ. Чингээд охиниг хичээлээсээ ирэхэд Банхар гэрт байсангүй. Аав нь “Түүнийг эхэд нь аваачиж өгсөн” гэж ярив. Бас ээж нь их адилхан байсан гэж нэмж хэллээ.




Гэвч Сацрал аавыгаа сонсох дургүй байв. “Нэг сахилгагүй хүүхэд гэлгийг эхээс нь салган орцонд орхисон байна” гэхийг нь чихнийхээ гадуур өнгөрөөжээ. Тэр уйлсаар. Амьд тоглоомыг нь явуулчихсан аав эзждээ гомдоллон уйлсаар байв аа.








Чингэтэл нүдэнд нь хaa нэгэнтээ чичрэн байгаа бяцхан найз нь харагдav. Тэр нь дахиад л гав ганцаархнаа болчихсон, хүн явдаггүй газар чичрэн сууж байх ажээ.




Ингээд охин цаас, зургийн хэрэгслээ гарган бяцхан гелгэндээ жижигхэн байшин зурлаа.








Зурсан байшинд Банхар орсонгүй. Өөр ямар нэгэн юм хүсэх адил өревдэлтэйгээр өөрийг нь ширтсээр. Охин жижигхэн байшиг дулаацуулах арга бодов. Байшигийнх нь яг орой дээр нар зурлаа.




Тэгэвч гелөг охиныг харсаар. "Нэг л зүйл дутуу байна даа" гэж зураач бодов. Тэгээд гелөгнийхөө өмнө амтат хоол зурлаа. Хоолыг тавганд хийхээ ч мартсангүй.



Гөлөг сүү рүү тонгойсон боловч долоосонгүй. Энэ нь Сацралыг айхавтар хүнд байдалд оруулсан аж. Түүнийг "Юу хэрэгтэй байгаагаа хэлээч дээ?" гэж шивнэхэд хүргэжээ. Шивнэх яах вэ, бодох л чухал! Тэгээд бодож бодож Банхартаа найз зурахаар шийдлээ. Яг өөртэй нь чацуу, гэхдээ арай л өөр бяцхан гөлөг зуржээ.




Хоёр гелгийг найзлан хөөцөлдөх юм бодсон тэгсэнгүй.
Банхар аанай л уйтгарласаар. Тэр охиноос ямар нэг юм
хүсэн харсаар л байх белгэе. Охин дахиад л бодол болов.
Өөрийгээ түүн дээр аваачих арга олтлоо бодолд автжээ.
Тэгзэд өөрийгээ гелегнийхөө дэргэд очуулан зурав.




Даанч Банхар зурган Сацралыг тоож ч харсангүй. Зураачийг л ширтээд байх юм. Тэгэхээр нь гөлгийг зурган хүүхдэд тэврүүлчхэв.

3

-Сайн түүхээг булагт нийдэй-




Бас л нэмэргүй. Сацral өөрийнхөө гэр доторх тавилгыг гөлөг тойруулан зурж гарлаа. Банхараа гэртээ авчирч байгаа нь тэр. Гэтэл тэр нь гөлөг урьдын адил зурган гэр дотор тонгочин гүйсэнгүй ээ. Хивсэн дээр хэвтэх бөмбөгийг ч тоож харсангүй.




Энэ удаад харин охин хар үст найздаа гомдлоо. Тэр гөлгийг
үтэр түргэн гадаа гаргаж зурав. Өндөр байшиングуудын дунд
шүү!

3

-Салхи шуурга зурж амжаагүй байтал охины



Эгээтэй л салхи шуурга зурж амжаагүй байтал охины толгойд нэгэн сайхан бодол харван орж ирлээ. Энэ нь түүний эхийг зурах явдал байв.



Хар үст ээжээ харан баярлахдаа урд хоёр хөлөө дээш өргөн дэвхцэв. Ээж нь түүнийг холоос үнэрлэнхэн угтах нь тэр ээ.



Сацрал охин зурсан зургаараа үзэсгэлэн гаргасан нь бусдад их таалагджээ. Ялангуяа эцэг эх нь туйлын баяртай байцаав. Сацралтай зэрэгцээд зурган адал явдалд оролцсон чи ч гэсэн "мундаг хүүхэд" шүү!



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.